

Kapungas
Batas

Kabungas Kabungas
Batas Kabungas
Kabungas.

[Signature] vi
083275 6



Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг	
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР	
ТТБ.2052	
Бүртгэсэн №	Харт №
Огноо	2018.06.06
.....цаг.....	минутанд
335	д
шилжүүлэв.	
Хуудасны тоо	7



**ДИПЛОМАТ, АЛБАН БОЛОН ЭНГИЙН ПАСПОРТ
ЭЗЭМШИГЧДИЙГ ВИЗИЙН ШААРДЛАГААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ
МОНГОЛ УЛС БОЛОН
ДОРНЫН БҮГД НАЙРАМДАХ УРУГВАЙ УЛС
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улс болон Дорнын Бүгд Найрамдах Уругвай Улс, цаашид
"Хэлэлцэн тохиролцогч талууд" гэх,

Хоёр улсын найрсаг харилцааг цаашид хөгжүүлэхийг эрмэлзэн,

Хүчинтэй дипломат, албан болон энгийн паспорт эзэмшигчдийг
визээс чөлөөлөх замаар Хэлэлцэн тохиролцогч талуудын иргэдийн
харилцан зорчих явдлыг хөхиүлэн дэмжих, хөнгөлөх, урамшуулахыг зорьж,

Дараахь зүйлийг хэлэлцэн тохиролцов:

1 дүгээр зүйл

Хэлэлцэн тохиролцогч Талуудын хүчинтэй дипломат, албан болон
энгийн паспорт эзэмшигч нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг
дэсвгэрт нэвтрэх, зорчих, нутаг дэвсгэрээс нь гарах, эсхүл дамжин
өнгөрөхөд нэвтэрсэн өдрөөс хойш гуч (30) хоногоос илүүгүй хугацаанд
визийн шаардлагаас чөлөөлөгдөнө.

2 дугаар зүйл

Хэлэлцэн тохиролцогч аль нэг Талын хүчинтэй дипломат, албан болон энгийн паспорт эзэмшигч Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт гуч (30) хоногоос илүү хугацаанд байх бол урьдчилан виз авна.

3 дугаар зүйл

Хэлэлцэн тохиролцогч Талуудын хүчинтэй дипломат, албан болон энгийн паспорт эзэмшигч Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт нэвтрэх, нутаг дэвсгэрээс нь гарах, эсхүл дамжин өнгөрөхөд тухайн Хэлэлцэн тохиролцогч Талын олон улсын зорчигчдод зориулсан хилийн боомтоор нэвтэрч, эсхүл гарах ба тухайн Хэлэлцэн тохиролцогч Талын шилжилт хөдөлгөөний хууль тогтоомжид заасан журмыг дагаж мөрдөх үүрэгтэй.

Хэлэлцэн тохиролцогч Талууд гадаад улсын иргэдийн нэвтрэх, гарах болон зорчих асуудалтай холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд энэ тухайгаа дипломат шугамаар харилцан мэдэгдэнэ.

4 дүгээр зүйл

Хэлэлцэн тохиролцогч Талуудын хүчинтэй дипломат, албан болон энгийн паспорт эзэмшигч нь Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талын нутаг дэвсгэрт зорчих хугацаандаа тухайн Хэлэлцэн тохиролцогч Талын хууль тогтоомжийг чандлан биелүүлэх үүрэгтэй.

5 дугаар зүйл

Хэлэлцэн тохиролцогч Талуудын хүчинтэй дипломат, албан болон энгийн паспорт эзэмшигчийг "тааламжгүй этгээд" гэж тооцсон тохиолдолд тухайн этгээдийг нэвтрүүлэх, зорчуулахаас татгалзах эрхийг Хэлэлцэн тохиролцогч Талууд эдэлнэ.

6 дугаар зүйл

Хэлэлцэн тохиролцогч Тал бүр үндэсний аюулгүй байдал, нийтийн дэг журам, эсхүл олон нийтийн эрүүл мэндийг хамгаалах зорилгоор энэхүү хэлэлцээрийн үйлчлэлийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн зогсоох эрхтэй. Ийм арга хэмжээ авах болон эгүүлэн цуцлах тухайгаа Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талдаа дипломат шугамаар урьдчилан мэдэгдэнэ.

7 дугаар зүйл

Хэлэлцэн тохиролцогч Талууд энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс хойш гуч (30) хоногийн дотор дипломат, албан болон энгийн паспортын загварыг дипломат шугамаар солилцоно.

Хэлэлцэн тохиролцогч аль нэг Тал шинэ дипломат, албан болон энгийн паспорт, мөн бичиг баримт нэвтрүүлэх, эсхүл өөрийн ашиглаж буй дипломат, албан, энгийн паспорт болон баримтад өөрчлөлт оруулах тохиолдолд харилцан мэдэгдэх бөгөөд тэрхүү шинэ, эсхүл өөрчлөлт оруулсан дипломат, албан, энгийн паспорт болон бичиг баримтын загварыг тэдгээрийг нэвтрүүлэх эсхүл өөрчлөлт орохоос доод тал нь гуч (30) хоногийн өмнө дипломат шугамаар Хэлэлцэн тохиролцогч нөгөө Талд хүргүүлнэ.

8 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх эсхүл хэрэглэхтэй холбогдон гарсан аливаа маргааныг Хэлэлцэн тохиролцогч Талууд дипломат шугамаар, зөвшилцөх замаар эв зүйгээр шийдвэрлэнэ.

9 дүгээр зүйл

Хэлэлцэн тохиролцогч Талууд бичгээр харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Нэмэлт, өөрчлөлт нь энэхүү Хэлэлцээрийн салшгүй хэсэг болох ба 10 дугаар зүйлд заасан журмын дагуу хүчинтэй болно.

10 дугаар зүйл

Энэхүү хэлэлцээр нь Хэлэлцэн тохиролцогч Талууд түүнийг хүчин төгөлдөр болоход шаардлагатай дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангасан тухайгаа дипломат шугамаар харилцан мэдэгдсэн сүүлийн бичгэн мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш гуч (30) хоног өнгөрмөгц хүчин төгөлдөр болно.

Энэхүү хэлэлцээрийг хугацаагүйгээр байгуулах бөгөөд Хэлэлцэн тохиролцогч аль нэг Талын зургаа (6) сарын өмнө дипломат шугамаар мэдэгдсэн цуцлах тухай мэдэгдлийн дагуу хэлэлцээр цуцлагдана.

Энэхүү хэлэлцээрийг Улаанбаатар хотноо 1998 оны 7 дугаар сарын 8 -ны өдөр монгол, испани, англи хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд адил хүчинтэй байна. Тайлбарлахад зөрүү гарвал англи хэлээрх эх бичвэрийг баримтална.

МОНГОЛ УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ



ДОРНЫН БҮГД НАЙРАМДАХ
УРУГВАЙ УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ



**AGREEMENT BETWEEN
MONGOLIA
AND
THE ORIENTAL REPUBLIC OF URUGUAY
ON THE EXEMPTION OF VISA REQUIREMENTS
FOR HOLDERS OF DIPLOMATIC, OFFICIAL
AND ORDINARY PASSPORTS**

Mongolia and The Oriental Republic of Uruguay hereinafter referred to as the "Contracting Parties",

Being guided by the desire to develop further friendly relations between the two States,

Desiring to promote, facilitate and encourage exchange of visits of nationals of the Contracting Parties by the exemption of visa requirements for holders of their valid diplomatic, official and ordinary passports;

Have agreed as follows:

ARTICLE 1

Holders of valid diplomatic, official and ordinary passports of either Contracting Party shall be exempted from visa requirements for entry into, stay in, exit from or transit through the territory of the other Contracting Party as the case maybe, for a period of the time not exceeding thirty (30) days from the date of their entry.

ARTICLE 2

Holders of valid diplomatic, official and ordinary passports of either Contracting Party, who wish to stay more than thirty (30) days in the territory of the other Contracting Party, shall obtain visa in advance.

ARTICLE 3

Holders of valid diplomatic, official and ordinary passports of either Contracting Party shall enter into, exit from or transit through ports of entry and exit open to international travelers of the other Contracting Party and follow all necessary formalities in accordance with the immigration laws and regulations of that Contracting Party.

The Contracting Parties undertake to notify each other on any amendments to their respective legislation to entry, exit and stay of foreigners through diplomatic channels.

ARTICLE 4

Holders of valid diplomatic, official and ordinary passports of either Contracting Party shall observe the laws and regulations of the other Contracting Party during their stay in that Contracting Party.

ARTICLE 5

Each Contracting Party shall reserve the right to deny the entry or the stay in its territory of holders of valid diplomatic, official and ordinary passports of either Contracting Party which are considered undesirable.

ARTICLE 6

Each Contracting Party may, for reason of ensuring national security, public order or public health, suspend this Agreement, either in whole or in part. The introduction and termination of such suspension shall be promptly notified in advance to the other Contracting Party through diplomatic channels.

ARTICLE 7

The Contracting Parties shall exchange through diplomatic channels, not later than thirty (30) days from the date of signing of this Agreement, the samples of their diplomatic, official and ordinary passports.

The Contracting Parties shall inform each other of their introduction of new diplomatic, official and ordinary passports or documents or of modifications to existing diplomatic, official and ordinary passports or documents, and shall transmit through diplomatic channels samples of the new or modified diplomatic, official and ordinary passports or documents at least thirty (30) days to their introduction or validity of any modification.

ARTICLE 8

Any dispute arising out of implementation or application of this Agreement shall be settled amicably by diplomatic consultations between the Contracting Parties.

ARTICLE 9

This Agreement may be amended in writing by the mutual consent of the Contracting Parties. Any such amendment, which shall form an integral part of this Agreement, shall come into effect in accordance with the procedures set forth in Article 10.


ARTICLE 10

This Agreement shall enter into force thirty (30) days from the date of receipt of the last written notification by which the Contracting Parties notify each other, through diplomatic channels, of completion of their internal legal procedures required for entry into force of this Agreement.

This Agreement shall remain in force for an indefinite period of time unless it is terminated by either Contracting Party upon a six (6) month prior written notice given to the other Contracting Party through diplomatic channels.

Signed in *Ulaanbaatar* on *April 8, 2018*. In two original copies, in Mongolian, Spanish and English languages, all texts being equally authentic. In case of divergences in interpretation, the English text shall prevail.

FOR MONGOLIA



FOR THE ORIENTAL
REPUBLIC OF URUGUAY



**ACUERDO
ENTRE MONGOLIA
Y LA REPÚBLICA ORIENTAL DEL URUGUAY
SOBRE LA SUPRESIÓN DE LA EXIGENCIA DE VISA
PARA LOS TITULARES DE PASAPORTES DIPLOMÁTICOS, OFICIALES Y
COMUNES DE AMBOS PAISES**

Mongolia y La República Oriental del Uruguay, en lo sucesivo "las Partes Contratantes",

Guiados por el deseo de desarrollar aún más las relaciones de amistad entre ambos países,

Deseosos de promover, facilitar y alentar el intercambio de visitas de los nacionales de las Partes Contratantes mediante la exención de la exigencia de visa a los titulares de pasaportes diplomáticos, oficiales y comunes de ambos países,

Han acordado lo siguiente:

ARTÍCULO 1

Los titulares de pasaportes diplomáticos, oficiales o comunes válidos de cualquiera de las Partes Contratantes, estarán exentos de la exigencia de visa para ingresar, salir o estar en tránsito en el territorio de la otra Parte Contratante, según sea el caso, por un máximo de treinta (30) días contados a partir de la fecha del ingreso.

ARTÍCULO 2

Los titulares de pasaportes diplomáticos, oficiales o comunes válidos de cualquiera de las Partes Contratantes que deseen permanecer en el territorio de la otra Parte Contratante por más de treinta (30) días, deberán obtener una visa por adelantado.

ARTÍCULO 3

Los titulares de pasaportes diplomáticos, oficiales o comunes válidos de cualquiera de las Partes Contratantes ingresarán, circularán, o saldrán del territorio de la otra Parte Contratante por los puntos de entrada y salida destinados al tráfico internacional de pasajeros de esa otra Parte Contratante y cumplirán las formalidades necesarias dispuestas por las leyes y disposiciones migratorias de esa Parte Contratante.

Las Partes Contratantes se comprometen a notificarse mutuamente sobre las enmiendas a sus respectivas legislaciones en relación con la entrada, salida y permanencia de extranjeros a través de los canales diplomáticos.

ARTÍCULO 4

Los titulares de pasaportes diplomáticos, oficiales o comunes válidos de cualquiera de las Partes Contratantes deberán cumplir con la legislación aplicable en el territorio de la otra Parte durante su estadía.

ARTÍCULO 5

Cada Parte Contratante se reservará el derecho de negar el ingreso o la permanencia en su territorio de los titulares de pasaportes diplomáticos, oficiales o comunes válidos, de la otra Parte Contratante, para el caso que los considere indeseables.

ARTÍCULO 6

Cualquiera de las Partes Contratantes podrá suspender total o parcialmente la aplicación del presente Acuerdo, por razones de seguridad nacional, orden, o salud pública. La Parte en cuestión notificará inmediatamente y por adelantado, por la vía diplomática, a la otra Parte del inicio y la finalización de la suspensión.

ARTÍCULO 7

Las Partes Contratantes intercambiarán especímenes de sus pasaportes diplomáticos, oficiales o comunes válidos, a los que se hace referencia en el presente Acuerdo, por la vía diplomática, dentro de los 30 (treinta) días siguientes a su firma.

Las Partes Contratantes se notificarán mutuamente de la introducción de nuevos modelos de pasaportes o documentos diplomáticos, oficiales y comunes, así como de las modificaciones a los pasaportes o documentos diplomáticos, oficiales y comunes e intercambiarán por la vía diplomática ejemplares de los nuevos pasaportes o documentos diplomáticos, oficiales y comunes con una antelación no menor a los 30 (treinta) días de la fecha de entrada en vigor de los nuevos pasaportes o documentos o de su modificación.

ARTÍCULO 8

Cualquier controversia que surja entre las Partes Contratantes respecto a la aplicación o interpretación del presente Acuerdo se resolverá amigablemente entre las Partes Contratantes mediante consultas diplomáticas.

ARTÍCULO 9

El presente Acuerdo podrá ser enmendado por escrito por mutuo consentimiento de las Partes Contratantes. Cualquiera de estas modificaciones, que será parte integral de este Acuerdo, entrará en vigor de conformidad con los procedimientos establecidos en el Artículo 10.


ARTÍCULO 10

El presente Acuerdo entrará en vigor treinta (30) días después de recibirse la última notificación escrita por la que las Partes Contratantes se informan mutuamente del cumplimiento de los requisitos internos exigidos para su entrada en vigor.

El presente Acuerdo tendrá una duración indefinida a partir de su entrada en vigor. Las Partes Contratantes podrán denunciar el presente Acuerdo por la vía diplomática mediante una notificación escrita enviada a la otra Parte Contratante seis (6) meses antes de hacerse efectiva la denuncia.

Hecho en Ulaanbaatar el April de 4 de 2018, en dos ejemplares, cada uno en idiomas mongol, español e inglés, siendo todos los textos igualmente auténticos. En caso de divergencia en su interpretación, prevalecerá el texto en inglés.

POR MONGOLIA



POR LA REPÚBLICA ORIENTAL
DEL URUGUAY